



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2013 оны 01 сарын 14. өдөр

Дугаар 10.

Улаанбаатар хот


Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9, 11.1.11 дэх заалт, 11.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм”-ийн 4.4 дэх заалт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/01 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Монгол Улсын Их Хурлын гишүүн гадаадад яваад мөрдөх журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын дэд дарга /С.Баярцогт, М.Энхболд, Л.Цог/, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга /Б.Болдбаатар/-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамж батлагдсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын даргын 2009 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 144 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



00000044

Монгол Улсын Их Хурлын даргын 2013 оны 1 дүгээр
сарын 17-ны өдрийн 10 тоот захирамжийн хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
ГАДААДАД ЯВАХАД МӨРДӨХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү журмыг Монгол Улсын Их Хурлын гишүүн /цаашид "Улсын Их Хурлын гишүүн" гэх/ гадаадад Улсын Их Хурал, Монголын парламентын бүлгэмийн шугамаар айлчлал хийх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын хийх төрийн болон албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орох, олон улсын хурал, зөвлөлгөөн болон бусад арга хэмжээнд оролцох, өөрийн сонгогдсон тойргийн болон хувийн ажлаар явах, амрах, эмчлүүлэх зорилгоор гадаадад явахад мөрдөнө.

1.2. Улсын Их Хурлын гишүүн албаны болон хувийн ажлаар гадаадад явах тухай бүрд зөвшөөрөл хүссэн хүсэлтээ явахаасаа ажлын таваас доошгүй өдрийн өмнө Улсын Их Хурлын даргад албан бичгээр ирүүлнэ. Улсын Их Хурлын гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар гадаадад явах зайлшгүй шаардлага гарч тухайн өдөр нь амралтын өдөр таарвал зөвшөөрөл хүссэн албан бичгээ тухайн 7 хоногийн ажлын эхний өдөрт багтаан Улсын Их Хурлын даргад нөхөн өгч болно.

1.3. Улсын Их Хурлын гишүүний гадаадад явах асуудлыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9, 11.1.11 дэх заалт, 11.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм"-ийн 4.4 дэх заалт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01 дүгээр зөвлөмжийн 3.1-ийн а)-д заасныг тус тус үндэслэн Улсын Их Хурлын дарга захирамж гаргаж шийдвэрлэнэ.

1.4. Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын гишүүнийг гадаадад явах зөвшөөрөл олгоходо түүний хариуцан боловсруулж байгаа болон хэлэлцүүлж байгаа хуулийн төсөл, хуралдааны ирц, тухайн Улсын Их Хурлын гишүүний гадаадад явсан байдал, Улсын Их Хурлын гишүүний харьялагдаж байгаа Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн санал болон дараах зүйлийг үндэслэн шийдвэр гаргана:

1.4.1. Улсын Их Хурлын гишүүн аль улсад ямар хугацаагаар, ямар ажлаар, хаанахын зардлаар явах тухайгаа дурдаж зөвшөөрөл хүссэн албан бичиг;

1.4.2. Улсын Их Хурлын гишүүнийг урьсан урилга, эсхүл албан бичиг;

1.4.3. тухайн арга хэмжээ Улсын Их Хурлын гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд туссан эсэх, төсөвлөсөн зардал байгаа эсэх /хувийн хэргээр зорчихоос бусад тохиолдолд/;

1.4.4. гадаадад явж эмчлүүлэх, оношлогоо хийлгүүлэх тохиолдолд Улсын Их Хурлын гишүүний бичгээр гаргасан хүсэлт, шаардлагатай тохиолдолд Клиникийн нэгдсэн II эмнэлгийн Гадаад эмчилгээний комиссын хурлын шийдвэр.

15

1.5. Улсын Их Хурлын гишүүнийг гадаадад явах тухай захирамжийг Улсын Их Хурлын даргын эзгүйд түүнийг орлож байгаа Улсын Их Хурлын дэд дарга энэ журамд заасны дагуу гаргана.

Хоёр. Улсын Их Хурлын гишүүн төрийн болон албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орох

2.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын гадаад улсад хийх төрийн болон албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орох Улсын Их Хурлын гишүүнийг Улсын Их Хурлын дарга тухайн айлчлал эхлэхээс арваас доошгүй хоногийн өмнө томилж захирамж гаргана. Айлчлалын бүрэлдэхүүнд орж байгаа Улсын Их Хурлын гишүүн шаардлагатай тохиолдолд ажлын удирдамж гаргаж Улсын Их Хурлын даргаар батлуулна.

2.2. Нэг удаагийн айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орох Улсын Их Хурлын гишүүний тоо хоёроос илүүгүй байх, ингэхдээ Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгээс ээлжлэн айлчлал хийх улсын парламенттай харилцах бүлгийн гишүүдээс оруулах зарчмыг баримтлах бөгөөд энэ нь Засгийн газрын гишүүнээр ажиллаж байгаа Улсын Их Хурлын гишүүнд хамаарахгүй.

2.3. Айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж байгаа Засгийн газрын гишүүнээр ажиллаж байгаагаас бусад Улсын Их Хурлын гишүүний зардлыг Улсын Их Хурал хариуцна.

2.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын гадаад улсад хийх айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн орох тохиолдолд холбогдох төсвийг Улсын Их Хурлын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс /цаашид “Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс” гэх/, Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, аж ахуй, үйлчилгээний хэлтэс /цаашид “Санхүү, аж ахуй, үйлчилгээний хэлтэс” гэх/ Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын албатай хамтран боловсруулж, айлчлал эхлэхээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар батлуулна.

Гурав. Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын даргын айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орох

3.1. Улсын Их Хурлын даргын гадаад улсад хийх албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд тухайн айлчлалын онцлогийг харгалзан Улсын Их Хурлын тав хүртэл гишүүн орж болно.

3.2. Айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд айлчлал хийх улсын парламенттай харилцах бүлгийн гишүүдээс голлон оруулах зарчим баримтална.

3.3. Айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг тухайн айлчлал эхлэхээс арваас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурлын дарга захирамжаар батална.

3.4. Улсын Их Хурлын даргын гадаад улсад хийх албан ёсны айлчлалтай холбогдох зохион байгуулалтын /айлчлалын хугацааг тохиорох, уулзалт ярианы сэдэв бэлтгэх, хөтөлбөр гаргах, төсөв батлуулах, онгоцны тийз захиалах, виз авах, зочид буудал, унаа захиалах г.м./ асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар түүний Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс хариуцан зохион байгуулна.

3.5. Улсын Их Хурлын даргыг гадаад улсад айлчлалаар явах, ирэхэд Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын албаны дарга, албаны бусад хүмүүс үдэж гаргах ба угтаж авна. Улсын Их Хурлын

дэд даргыг гадаад улсад албан ажлаар явах, ирэхэд Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн зөвлөх үдэж гаргах ба угтаж авна.

3.6. Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүнийг гадаад улсад албан ажлаар явах, ирэхэд үдэх, угтах, “ВИП” танхимын зөвшөөрөл авах ажлыг тухайн Байнгын хорооны ажлын албаны ажилтан, тухайн Улсын Их Хурлын гишүүний туслах хариуцан зохион байгуулах бөгөөд Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсээс холбогдох дэмжлэг үзүүлнэ.

3.7. Улсын Их Хурлын гишүүн төрийн болон албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ороход уг айлчлалтай холбогдох зохион байгуулалтын ажлыг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс Гадаад харилцааны яамны холбогдох газартай хамтран хийх бөгөөд айлчлалын бэлтгэл ажилд тухайн Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслахыг оролцуулна.

3.8. Улсын Их Хурлын даргын захирамжаар гадаадад явах Улсын Их Хурлын гишүүн тухайн улсад очих өдөр, онгоцны нислэгийн хуваарь, нисэх буудал дээр угтуулах, үдүүлэх, дамжин өнгөрөх хотод зочид буудал захиалах зэрэг зохицуулах шаардлагатай асуудлаа Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст явахаасаа долоо хоногийн өмнө мэдэгдэнэ.

Дөрөв. Улсын Их Хурлын гишүүн парламент хоорондын харилцааны шугамаар гадаадад явах

4.1. Улсын Их Хурлын болон Монголын парламентын бүлгэмийн гадаад арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөний дагуу гадаад улсын парламентад ажлын айлчлал хийх төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орох Улсын Их Хурлын гишүүдийн тоо дөрвөөс илүүгүй байх бөгөөд төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд тухайн улстай харилцах парламентын бүлгийн дарга, гишүүдээс голлон оруулах зарчим баримтална.

4.2. Улсын Их Хурлын хэд хэдэн гишүүдээс бүрдсэн төлөөлөгчид гадаадад албан ажлаар явах бол Улсын Их Хурлын дарга төлөөлөгчдийн тэргүүнийг томилно. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүний тоог тогтоохдоо Улсын Их Хурал дахь нам, эвслийн суудлын тоог харгалzan үзнэ.

4.3. Улсын Их Хурлын гишүүний парламент хоорондын харилцааны шугамаар гадаадад явахтай холбогдсон бүх бэлтгэл ажлыг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс хариуцаж, холбогдох захирамж болон төсвийг тухайн айлчлал эхлэхээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө батлуулна.

4.4. Улсын Их Хурлын гишүүн гадаадад явахдаа Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01 дүгээр зөвлөмжид заасныг баримтална.

Тав. Улсын Их Хурлын гишүүн дотоод, гадаадын байгууллага, сангийн шугамаар гадаадад явах

5.1. Улсын Их Хурлын гишүүн дотоод, гадаадын байгууллага, сангийн шугамаар гадаадад явах бол энэ журмын 1.2, 1.4-т заасны дагуу зөвшөөрөл авна.

5.2. Улсын Их Хурлын дарга тодорхой үндэслэл, шалтгааны улмаас Улсын Их Хурлын гишүүнийг дотоод, гадаадын байгууллага, сангийн шугамаар гадаадад явахыг зөвшөөрөх боломжгүй бол энэ тухайгаа тухайн Улсын Их Хурлын гишүүнд мэдэгдэнэ.

5.3. Улсын Их Хурлын гишүүн парламент хоорондын харилцаанаас бусад асуудлаар олон улсын хурал, зөвлөлгөөнд оролцон илтгэл тавих, үг хэлэх бол тухайн асуудлыг

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандаж илтгэл, хэлэх үгийн төслийг орчуулгын хамт бэлтгүүлэх хүсэлт тавьж болох бөгөөд энэ тухайгаа Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст мэдэгдэнэ.

5.4. Улсын Их Хурлын гишүүн гадаадад явахад виз авах шаардлагатай бол Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс тухайн Улсын Их Хурлын гишүүний туслахтай хамтран холбогдох ажлыг зохион байгуулна. Улсын Их Хурлын гишүүнтэй хамт явах Улсын Их Хурлын гишүүний эхнэр /нөхөр/ болон дагалдан явах Тамгын газрын ажилтнаас бусад хүнд виз авах асуудлыг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс хариуцахгүй.

5.5. Улсын Их Хурлын гишүүн дотоод, гадаадын байгууллага, сангийн шугамаар гадаадад явахтай холбогдсон зохион байгуулалтын ажлыг /нисэх онгоцны буудлын "ВИП" танхимаар үйлчлүүлэх зөвшөөрлийн бичиг, унаа захиалах, үдэж гаргах, угтаж авах г.м./ тухайн Улсын Их Хурлын гишүүний туслах Төрийн ёслолын алба болон Санхүү, аж ахуй, үйлчилгээний хэлтэст захиалга өгч зохион байгуулах бөгөөд Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс туслалцаа үзүүлнэ.

Зургаа. Улсын Их Хурлын гишүүн хувийн ажлаар гадаадад явах

6.1. Улсын Их Хурлын гишүүн хувийн ажлаар гадаадад явахтай холбогдох зохион байгуулалтын бүх ажлыг тухайн Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслах хариуцна.

6.2. Улсын Их Хурлын гишүүн хувийн ажлаар гадаадад явахад виз авах шаардлагатай бол Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс туслалцаа үзүүлэх бөгөөд энэ нь Улсын Их Хурлын гишүүнтэй хамт явах бусад хүнд хамаарахгүй.

Долоо. Гадаадад албан ажлаар явсан тухай тайлاغнах

7.1. Улсын Их Хурлын даргын гадаад улсад хийсэн албан ёсны айлчлалын дүнг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

7.2. Улсын Их Хурлын дэд дарга, Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын шугамаар гадаадад айлчлах, албан ажлаар явахад Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн ажилтан дагалдан яваагүй тохиолдолд тухайн Улсын Их Хурлын гишүүн гадаадад явсан тухай илтгэх хуудас, уулзалт ярианы тэмдэглэл, тайлангаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01 дүгээр зөвлөмжийн 3.1-ийн б),в)-д заасны дагуу гаргана.

7.3. Энэ журмын 7.2-т заасан илтгэх хуудас, тайланд удирдамжийн хэрэгжилт, үр дүн, анхаарвал зохих асуудал, цаашид авах арга хэмжээний саналыг тодорхой тусгана.

7.4. Улсын Их Хурлын гишүүн гадаадад албан ажлаар явж ирээд ажлын гурван өдөрт багтаан томилолтын зардлын тооцоог Санхүү, аж ахуй, үйлчилгээний хэлтэстэй хийнэ. Улсын Их Хурлын гишүүнийг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн ажилтан дагалдан яваагүй тохиолдолд томилолтын зардлын тооцоог тухайн гишүүн өөрөө, эсхүл түүний туслах хийнэ.

Найм. Бусад зүйл

8.1. Айлчлалын болон гадаадад албан ажлаар явах төлөөлөгчдийн бүрэлдэхүүний тоог Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн гишүүдийн тоог харгалzan тогтоох ба аль нэг бүлэгт харьялагддаггүй Улсын Их Хурлын гишүүнийг гадаад томилолтод ээлжлэн оролцуулах зарчмыг баримтална.

8.2. Улсын Их Хурлын гишүүн гадаадад явахдаа энэ журмын 1.3, 1.5-д заасны дагуу Улсын Их Хурлын дарга, дэд даргаас зөвшөөрөл авч захирамж гаргуулаагүй бол захирамжийг нөхөж гаргахгүй.

8.3. Улсын Их Хурлын гишүүн гадаадад явахад дараах зарчмыг баримтална.

8.3.1. хувийн хэвшлийн байгууллага, хувь хүний зардлаар гадаадад явахгүй байх;

8.3.2. тухайн үед Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй холбоотой гадаад улсын иргэн, аж ахуйн нэгжийн зардлаар явахгүй байх;

8.3.3. Улсын Их Хурлын даргын захирамжаар зөвшөөрөгдсөн улсаас өөр улсад зорчих, гадаад томилолтыг өөрчлөх, Улсын Их Хурлын бусад гишүүнтэй томилолтоо солих, зөвшөөрөгдсөн хугацаа, батлагдсан томилолтын зардлыг хэтрүүлэхгүй байх.

8.4. Энэ журмын 1.3, 1.5-д заасан захирамжгүйгээр гадаадад явсан болон энэ журмын 8.3-т заасныг зөрчсөн Улсын Их Хурлын гишүүнийг Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргасан гэж үзэх бөгөөд Улсын Их Хурлын дарга энэ талаар тухайн Улсын Их Хурлын гишүүнд хэлж сануулах, зөрчлийг удаа дараа давтан гаргасан тохиолдолд цаашид гадаад арга хэмжээнд оролцуулахаас татгалзах, шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороонд мэдэгдэнэ.

8.5. Улсын Их Хурлын гишүүн энэ журмын 1.3, 1.5-д заасан захирамжгүйгээр гадаадад явснаар Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд оролцоогүй нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил тасалсанд тооцогдоно.

8.6. Улсын Их Хурлын дарга зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд Улсын Их Хурлын чуулганы үеэр Улсын Их Хурлын гишүүнийг гадаадад явахыг түр хугацаагаар хязгаарлаж болно.

8.7. Улсын Их Хурлын даргын зөвшөөрөлгүйгээр Улсын Их Хурлын гишүүн гадаадын зочин төлөөлөгчийг Улсын Их Хурлын нэрийн өмнөөс урихыг хориглоно.

8.8. Улсын Их Хурлын гишүүн төрийн болон албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орох болон Улсын Их Хурлын зардлаар гадаадад албан ажлаар явахад нисэх онгоцны тийзийн үнийг энгийн ангиллын үнээр тооцох бөгөөд тухайн Улсын Их Хурлын гишүүн бизнес ангиллаар зорчихыг хүсвэл нисэх онгоцны тийзийн үнийн зөрүүг хувиасаа төлнө.

8.9. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс Улсын Их Хурлын гишүүний гадаадад явсан байдлын талаарх мэдээг тухай бүрд нь гаргаж хагас жилд нэг удаа Улсын Их Хурлын даргад танилцуулна.

-----оОо-----